



Долоо хоног тутмын хэвлэл  
2015 оны 09 дүгээр сарын 07  
№33 /894/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

1681

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

1684

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

1685

Засгийн газарт чиглэл  
өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хууль  
батлагдсаны 25 жилийн ойг  
ёслон тэмдэглэх тухай

“Сумын төвийн шинэчлэл”  
төслийн хүрээнд хийх ажлын  
жагсаалтыг шинэчлэн  
батлах тухай



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

431.	Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 144	1681
432.	Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 148	1683
433.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 149	1683
434.	Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг ёслон тэмдэглэх тухай	Дугаар 151	1684

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

435.	“Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай	Дугаар 265	1685
436.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 266	1696

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар  
хот

#### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Иргэдийг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжилтэй болгох, олимп, тив, дэлхийн спортын уралдаан, тэмцээнд амжилттай оролцох баг, тамирчдыг бэлтгэх үндсийг бий болгох зорилгоор Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай.

1/ үндэсний болон хөлбөмбөг, хоккейн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан барилга байгууламжийн цогцолборыг нийслэл Улаанбаатар хот болон боломжтой бусад суурин



газарт бариулах, газрын асуудлыг шийдвэрлэх, дотоод, гадаадын зохих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх;

2/ ерөнхий, мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын хичээлийн сургалтын төлөвлөгөөнд заасан цагт багтаан үндэсний болон багийн спортын агуулгыг нэмэгдүүлэх, сурагч, оюутныг үндэсний болон багийн спортоор хичээллэх таатай орчин, нөхцөлөөр хангах, энэ чиглэлээр биеийн тамирын багш нарыг мэргэшүүлэх;

3/ багийн спортын үндэсний шигшээ багийн олимп, тив, дэлхийн уралдаан, тэмцээнд оролцох төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4/ үндэсний болон багийн спортын барилга байгууламжийн цогцолборт түшиглэсэн багийн спортын мэргэжлийн сургалттай академи бий болгох, спортын сургалттай дунд сургуульд тухайн чиглэлээр анги нээх, мэргэжлийн болон боловсролын байгууллагууд дэргэдээ үндэсний болон багийн спортын төрлүүдийг клуб хэлбэрээр зохион байгуулж ажиллах, уралдаан, тэмцээн зохион байгуулах, Монгол Улсын тамирчид гадаад улсын баг, тамирчидтай бэлтгэл хийх, хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих;

5/ биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор гадаадын хандивлагчид болон холбогдох байгууллагаас өгсөн тусламж, техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл зэргийг гаалийн татвараас зохих хэмжээгээр чөлөөлөх хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх;

Хоёр. Үндэсний болон багийн спортын тамирчдыг ивээн тэтгэх, урамшуулах, барилга байгууламж барих, шинэ технологийг нэвтрүүлэх зэргээр Монгол Улсад үндэсний болон багийн спортыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулагч, хандивлагчдад уриалсугай.

Гурав. Зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчид болон олон нийтэд жил бүр мэдээлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**ЧИМЭДИЙН  
САЙХАНБИЛЭГ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Чадраагийн Энхтөрийг Говь-Алтай, Завхан аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Нямдоогийн Баярмаа, Замбалын Баярмаа нарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Мянганы Оюунцэцэгийг Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Ганболдын Дэлгэрсайханыг Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар  
хот

### **Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Чадраагийн Энхтөрийг Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг ёслон тэмдэглэх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Монгол Улсын Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн баярыг 2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улс даяар ёслон тэмдэглэсүгэй.

Хоёр. Энэхүү түүхт ойг угтаж холбогдох судалгаа шинжилгээ, соёлын бүтээлүүд туурвих, баримтат уран сайхны зохиомж бүтээх, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг бичихэд оролцсон, төр, нийгэм, соёлын зүтгэлтнүүдэд хүндэтгэл үзүүлэх, тэдний дурсгалыг мөнхжүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсугай.

Гурав. Энэ зарлигт дурдсан ажлыг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**ЧИМЭДИЙН  
САЙХАНБИЛЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2015 оны 6 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 265

Улаанбаатар  
хот

**“Сумын төвийн шинэчлэл”  
төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг  
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын технологийн шийдэл болон гүйцэтгэлийн явц, чанар байдал, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар болон холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан ““Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 309 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Д.ЦОГТБААТАР**



Засгийн газрын 2015 оны 265 дугаар  
тогтоолын хавсралт

“СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД  
ХИЙХ АЖЛЫН ЖАГСААЛТ

(сая төг.)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Гарсан санхүүжилтийн дүн	2015 онд санхүүжүүлэх дүн
		Эхэлсэн	Дуусах			
1	<b>Архангай – Тариат сум</b>	2014	2015	5,000.0	3,584.4	1,415.6
	<u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u> -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
	<u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Гүний худаг -Усан сан -Насос станц -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө -Халаалтын зуух -Хатуу хучилттай авто зам -Хайрган хучилттай авто зам -Явган хүний зам -Зам талбайн гэрэлтүүлэг -Ногоон байгууламж					



2	<b>Баян-Өлгий – Цэнгэл сум</b>	2014	2015	5,000.0	3,231.4	1,768.6
	<u>А.Зураг төсөв боловсруулах</u> <u>ажил:</u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
	<u>Б.Инженерийн дэд бүтцийн</u> <u>ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Гүний худаг -Усан сан -Насос станц -Цахилгаан хангамжийн дэд өртөө -Хатуу хучилттай авто зам -Явган хүний зам -Зам талбайн гэрэлтүүлэг					
	<u>В.Барилгын ажил:</u> -Соёл, аялал жуулчлалын үйлчилгээний болон мэдээллийн төвийн барилга (300 хүний суудалтай)					
3	<b>Булган – Хутаг-Өндөр сум</b>	2014	2015	5,000.0	3,085.7	1,914.3
	<u>А.Зураг төсөв боловсруулах</u> <u>ажил:</u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					





	<p><u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Халаалтын зуух -Насос станц -Гүний худаг -Хуучин худаг, уст цэгийн засвар -Усан сан -Ус цэвэршүүлэх станц -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө -Хатуу хучилттай авто зам -Явган хүний зам -Зам талбайн гэрэлтүүлэг -Ногоон байгууламж</p>					
4	<p><b>Говь-Алтай – Дэлгэр сум</b></p> <p><u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>	2014	2016	5,000.0	2,607.3	1,099.1
	<p><u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Халаалтын зуух -Үерийн далан -Насос станц -Гүний худаг -Усан сан -Ус цэвэршүүлэх станц -Цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд өртөө -Хатуу хучилттай авто зам -Зам талбайн гэрэлтүүлэг -Ногоон байгууламж</p>					



5	<b>Дорнод – Баян-Уул сум</b>	2014	2015	5,000.0	4,008.6	991.4
	<u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u> -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
6	<b>Дундговь – Өлзийт сум</b>	2014	2016	5,000.0	2,433.7	1,507.5
	<u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
	<u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Гүний худаг -Усан сан -Цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд өртөө -Хатуу хучилттай авто зам -Явган хүний зам -Зам талбайн гэрэлтүүлэг					
	<u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Гүний худаг -Усан сан -Ус цэвэршүүлэх станц -Ус түгээх байр -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө -Хатуу хучилттай авто зам -Явган хүний зам -Зам талбайн гэрэлтүүлэг -Хашаа, хайс					



	<u><i>В.Барилгын ажил:</i></u> -Халуун усны барилга					
7	<b>Завхан – Тосонцэнгэл сум</b>	2014	2015	4,996.0	3,413.0	1,583.0
	<u><i>А.Зураг төсөв боловсруулах ажил:</i></u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
	<u><i>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</i></u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Гүний худаг -Усан сан -Халаалтын зуухны өргөтгөл -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө -Хамгаалалтын хашаа (1-р бүсийн)					
8	<b>Өвөрхангай – Богд сум</b>	2014	2015	5,000.0	4,494.3	505.7
	<u><i>А.Зураг төсөв боловсруулах ажил:</i></u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
	<u><i>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</i></u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Гүний худаг -Усан сан -Ус цэвэршүүлэх станц -Цахилгаан хангамжийн дэд өртөө -Гадна тохижилт					



	<u>В.Барилгын ажил:</u> -8 айлын 2 ш орон сууцны халаалтын системийн засвар, дотор цэвэр, бохир усны шугамын холболт					
9	<b>Өмнөговь – Цогт-Овоо сум</b>	2014	2015	5,000.0	4,370.5	629.5
	<u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u> -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					
	<u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламж -Насос станц -Гүний худаг -Усан сан -Халаалтын зуух -Хатуу хучилттай авто зам -Явган хүний зам -Зам талбайн гэрэлтүүлэг					
	<u>В.Барилгын ажил:</u> -Албан байгууллагын гадна засвар					
10	<b>Сүхбаатар – Эрдэнэцагаан сум</b>	2014	2016	5,000.0	3,213.5	884.4
	<u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах					



	<p><u><b>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</b></u>                  -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ                  -Цэвэрлэх байгууламж                  -Гүний худаг                  -Усан сан                  -Халаалтын зуух                  -Цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд өртөө                  -Автозамын шороон далан                  -Явган хүний зам                  -Талбайн гэрэлтүүлэг                  -Төв талбайн тохижилт                  -Цэцэрлэгт хүрээлэн                  -Газар чөлөөлөлт</p>					
	<p><b>Сэлэнгэ – Цагааннуур сум</b></p>					
	<p><u><b>А.Зураг төсөв боловсруулах ажил:</b></u>                  -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах                  -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>					
11	<p><u><b>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</b></u>                  -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ                  -Цэвэрлэх байгууламж                  -Гүний худаг                  -Усан сан                  -Халаалтын зуух                  -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө</p>	2014	2015	5,000.0	4,622.8	377.2
	<p><b>Төв – Лүн сум</b></p>					
	<p><u><b>А.Зураг төсөв боловсруулах ажил:</b></u>                  -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах                  -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>					
12	<p><u><b>А.Зураг төсөв боловсруулах ажил:</b></u>                  -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах                  -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>	2014	2015	4,978.9	4,336.9	642.0



	<p><u><i>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</i></u>          -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ          -Цэвэрлэх байгууламж          -Гүний худаг          -Усан сан          -Ус цэвэршүүлэх станц          -Цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд өртөө          -Хатуу хучилттай автозам          -Явган хүний зам          -Зам талбайн гэрэлтүүлэг</p>					
	<p><u><i>В.Барилгын ажил:</i></u>          Сургуулийн дотуур байрны их засвар, ЗДТГ-ын засвар, Иргэний танхимын барилгын ажил, 64 м<sup>2</sup> талбай бүхий 4 айлын орон сууцны барилга угсралтын ажил, сургуулийн хашаанд спортын талбай байгуулах, сумын гэрэлтүүлэг, тохижилтын ажлууд</p>					
13	<p><b>Увс – Тэс сум</b></p> <p><u><i>А.Зураг төсөв боловсруулах ажил:</i></u>          -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах          -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p> <p><u><i>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</i></u>          -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ          -Цэвэрлэх байгууламж          -Насос станц          -Гүний худаг          -Усан сан          -Халаалтын зуух          -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө          -Явган хүний зам          -Зам талбайн гэрэлтүүлэг</p>	2014	2015	4,980.0	4,305.3	674.7



	<p><u><i>В.Барилгын ажил:</i></u> -Нутгийн удирдлагын ордны барилга -Халаалтын зуухны барилгын засвар -Авто гараш</p>					
14	<b>Ховд – Зэрэг сум</b>	2014	2015	5,000.0	3,042.9	1,957.1
	<p><u><i>А.Зураг төсөв боловсруулах ажил:</i></u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>					
	<p><u><i>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</i></u> -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ -Цэвэрлэх байгууламжийн өргөтгөл -Гүний худаг -Усан сан -Халаалтын зуух -Цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд өртөө -Сумын төвийн тохижилт, хашаа -Бохир ус соруулах автомашин (5 м<sup>3</sup>, 1 ширхэг)</p>					
	<p><u><i>В.Барилгын ажил:</i></u> -Цэцэрлэгийн барилга (100 хүүхдийн ортой)</p>					
15	<b>Хөвсгөл - Цэцэрлэг сум</b>	2014	2015	5,000.0	2,071.9	2,928.1
	<p><u><i>А.Зураг төсөв боловсруулах ажил:</i></u> -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>					



	<p><u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u>          -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ          -Цэвэрлэх байгууламж          -Гүний худаг          -Усан сан          -Халаалтын зуухны өргөтгөл          -Цахилгааны шугам, дэд өртөө          -Хатуу хучилттай авто зам          -Явган хүний зам</p>					
	<p><u>В.Барилгын ажил:</u>          -Ахуйн үйлчилгээ-халуун усны барилга</p>					
16	<p><b>Хэнтий – Биндэр сум</b></p>	2014	2015	5,000.0	4,000.5	999.5
	<p><u>А.Зураг төсөв боловсруулах ажил:</u>          -Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах          -Ажлын зураг төсөл, төсөв боловсруулах</p>					
	<p><u>Б.Инженерийн дэд бүтцийн ажил:</u>          -Сумын төвийн зарим албан байгууллагын гадна, дотор дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ          -Цэвэрлэх байгууламж          -Насос станц          -Гүний худаг          -Усан сан          -Халаалтын зуух          -Цахилгааны шугам сүлжээ, дэд өртөө          -Хатуу хучилттай авто зам          -Зам талбайн гэрэлтүүлэг, тохижилт          -Бусад ажил</p>					
<b>НИЙТ ДҮН</b>				<b>79,954.9</b>	<b>56,822.7</b>	<b>19,877.7</b>





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 6 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 266

Улаанбаатар  
хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Номын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2004 оны 9 дүгээр сарын 15–ны өдрийн 196 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “Хүүхдийн номын ордон” гэснийг “Хүүхдийн төв номын сан” гэж өөрчилсүгэй.

2. Хүүхдийн төв номын сангийн барилга шинээр барих газрын асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг дарга Э. Бат-Үүлд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

**Л.ГАНТӨМӨР**

#### Хяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003